ӨМНӨГОВЬ АЙМАГ
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2018 оны 01 сарын 19 өдөр | Дугаар А/06 | Даланзадгад

Мэдээлэл сургалт сурталчилгааны нэгдсэн
төлөвлөгөө батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын А/11 дүгээр захирамжаар 2018 оныг "Эрүүл мэндийг дэмжих" жил болгон зарласан тухай захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх зориогоор 2018 онд Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарын зохион байгуулах олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үнэлэх арга зүйг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Эрүүл зан үйл төлөвшүүлэх олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тэмдэглэлт өдөр, компанит ажил, аян зэрэг мэдээлэл сурталчилгааны олон талт үйл ажиллагааг сум орон нутгийн түвшинд цаг хугацаанд нь зохион байгуулан, хяналт тавьж, ард иргэдийн эрүүл мэндээ хамгаалах хариуцлага, оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлж ажиллахыг нийт эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /М.Булганчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 01 сарын 19 -ны өдрийн
А/06 тоот тушаалын 1 нэгдүгээр хавсралт

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2018 ОНД ИРГЭДИЙН ДУНД ЭРҮҮЛ ЗАН ҮЙЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үйл ажиллагааны чиглэл | Хүргэх гол мэдээлэл | Зорилтод бүлэг | Хариуцах байгууллага | Хүргэх хэлбэр | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хөлдөлт осголт, зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх | -Осголт хөлдөлтийн үед үзүүлэх анхны тусламж<br>-Дулаан хувцаслалт<br>- Техникийн бүрэн бүтэн байдал | Малчид<br>Жолооч<br>Эцэг эхчүүд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх<br>Гарын авлага тараах материалаар хангах.<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх | Нэгдүгээр сар |
| 2. | Амьсгалын замын халдварт өвчин болон томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх | Дулаан хувцаслалт<br>-Дархлаа дэмжсэн эрүүл хоол хүнс хэрэглэх<br>-Гар угаах, амны хаалт хэрэглэх<br>-өвдсөн тохиолдолд эмчид үзүүлж, гэрээр хэрхэн асарч эмчлэх<br>-Зөв ханиаж найтааж сурах | Сургууль цэцэрлэгийн багш нар<br>Эцэг эхчүүд<br>Сургууль цэцэрлэгийн хүүхдүүд<br>Олон нийтийн үйлчлүүлдэг албан байгууллага аж ахуй нэгж | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт | Нэгдүгээр сар |
| 3. | "Малчдын эрүүл мэндийг дэмжье" | -Мал амьтнаас хүнд халдварлах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Малчид<br>Мал аж ахуйн мэргэжилтнүүд | ЭМГ<br>ЗӨСТөв<br>СДЭ<br>Сум, Өрхийн | Мэдээлэл сурталчилгаа хийх<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор | Хоёрдугаар сар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | -Төл хүлээн авах, бэрхшээсэн төл гардах, арьс шир бэлтгэх, өтөг бууц цэвэрлэхдээ амны хаалт, хормогч, бээлий зэрэг хамгаалах хэрэгсэл өмсөх | | ЭМТөв | зөвлөгөө мэдээлэл хүргэх | |
| 4. | Баяр ёслолын үйл ажиллагаар архи согтууруулах ундаагүй тэмдэглэн өнгөрүүлэх хөдөлгөөн | Архины хор уршиг талаар<br>Архигүй хамт олон, баг, сум болох хөдөлгөөн<br>Баяр ёслолын үйл ажиллагаар архи согтууруулах ундаагүй тэмдэглэх тухай сурталчилах | 21-ээс дээш насны эрэгтэйчүүд эмэгтэйчүүд<br>Шийдвэр гаргагч нар<br>Байгууллага хамт олон | ЭМГ<br>ЗӨСТөв<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Нөлөөллийн сургалт, уулзалт<br>Зурагт хуудас, уриалга<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх | Хоёрдугаар сар |
| 5. | "Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд" | НҮЭМ<br>Гэр бүл төлөвлөлт<br>Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгсэл Жирэмсний хяналтын ач холбогдол | 13-18 насны Өсвөр үеийнхэн<br>18-45 Насны эмэгтэйчүүд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Үе тэнгийн сургалт<br>Өртөөчилсөн сургалт<br>Зөвлөгөө өгөх | Гуравдугаар сар |
| 6. | Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих 7 хоног | Хорт зуршлын хэрэглээ<br>Идэвхтэй хөдөлгөөн<br>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд эрт хамрагдах | Бүх насны эрэгтэйчүүд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Халдварт бус болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж өвчлөлийг эрт илрүүлэх, эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг судлах, эрүүл зан үйл төлөвшүүлэх сэдэл төрүүлэх | Гуравдугаар сар |
| 7. | Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр | Урьдчилан сэргийлэх үзлэг<br>Урьдчилан сэргийлэлт<br>Өвчлөлийн мэдээлэл | Залуучуудад<br>Хавьтагсдад<br>Эрсдэлт бүлгийн хүн амд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>СЭМТ<br>ӨЭМТ | Иргэдэд сургалт хийх<br>Зөвлөгөө өгөх<br>Эмээ тогтмол ууж байгаад хяналт тавих<br>Зорилтод насны хүн амыг эрт илрүүлэгт хамруулах | Гуравдугаар сар |
| 8. | Дэлхийн эрүүл мэндийн өдөр | Орон нутгийн хүн амын дунд зонхилон тохиолдох ХБӨ, ХӨ-ний урьдчилан сэргийлэх<br><br>Тухайн сард нь үйл ажиллагааны агуулга, сэдэв нь хүргэгдэнэ. | Нийт хүн ам | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>СЭМТ<br>ӨЭМТ | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Интернет олон нийтийн | Дөрөв-дүгээр сар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сүлжээгээр мэдээлэл хүргэх | |
| 9. | Идэвхтэй хөдөлгөөн – Өглөөний гүйлт | Албан байгууллага хамт олныг өглөөний гүйлт, дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамруулах, тогтмол гүйж хэвших | Нийт хүн ам | ЭМГ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Өглөөний гүйлт, алхалтын аян | Дөрөв-дүгээр сар |
| 10. | Дархлаажуулалтын үндэсний өдрүүд | Дархлаажуулалт гэж юу вэ<br>Дархлаажуулалтын ач холбогдол<br>Дархлаажуулалтын үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцоо | Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд<br>Нийт хүн ам | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Интернет олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэх | Тавдугаар сар |
| 11. | 5 дугаар сарын 31<br>Тамхи татахгүй дэлхийн өдөр | Тамхины хор уршиг талаар<br>Тамхиа хаясан үед хүний биед гарах эерэг өөрчлөлт<br>Тамхинаас татгалзах арга зам | 15-24 насны охид хөвгүүд, залуучууд<br>Тамхийг өдөр бүр хэрэглэдэг хүмүүс | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Орон нутгийн тамхи татдаг иргэдийн судалгааг гаргах<br>Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радио, интернет олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэх | Тавдугаар сар |
| 12. | Даралт ихсэх өвчинтэй тэмцэх, тархинд цус харвалт, зүрхний шигдсэнээс урьдчилан сэргийлэх | Даралтын эмээ тогтмол уух зөвлөгөө мэдээлэл<br>Даралтаа хянах, даралтаа хэмжиж сурах арга техникт суралцах<br>Эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, стресс уур бухимдлаа зохицуулах | Даралт ихсэх өвчтэй иргэд<br>Түүний гэр бүл<br>Эрсдэлт бүлгийн хүн ам | СЭМТ, ӨЭМТ, СДЭ, БОЭТ | Иргэдэд сургалт хийх<br>Зөвлөгөө өгөх<br>Гэрийн эргэлт хийх<br>Эмээ тогтмол ууж байгаад хяналт тавих<br>Зорилтод насны хүн амыг эрт илрүүлэгт хамруулах | Тавдугаар сар |
| 13. | Гэдэсний халдвараас сэргийлэх үе | Гараа зөв угаах<br>Хөрс, орчны бохирдлоос сэргийлэх<br>Бие засах газрын ариутгал, халдваргүйтгэл | Бага насны хүүхдүүд<br>Эцэг эхчүүд<br>Цэцэрлэг сургуулийн багш, | ЭМГ<br>ЗӨСТөв<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах | Тавдугаар сар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бие засах газрын стандарт | эмч нар | | Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br><br>Интернет олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэх | |
| 14. | Ахуйн осол гэмтэл, зам тээврийн осол гэмтлээс сэргийлье | Халуун хоол цайг хүүхдээс хол байлгах<br>Гэрийн орчинд хүүхэд өндрөөс унах, хавчуулагдах, түлэгдэх, тогонд цохиулахаас сэргийлэх<br>Химийн болон эмийн бодист хордохоос сэргийлэх<br>Насанд нь тохирсон тоглоом, спортын хэрэгслийг сонгож хэрэглэхийг зөвлөх | Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд | ЭМГ<br>БОЭТөв<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br><br>Интернет олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэх | Зургаан сар |
| 15. | Бүх нийтээрээ дугуй унаа аян | Албан байгууллага хамт олноороо идэвхтэй хөдөлгөөн нийтийн биеийн тамираар хичээллэх | Насанд хүрэгчид | ЭМГ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Бүх нийтээрээ дугуй унаа сарын аян зохион байгуулах | Долоодугаар сар |
| 16. | Гепатитын эсрэг тэмцэх өдөр | Элэгний вирус гэж юу вэ<br>Элгээ хэрхэн хамгаалах<br>Вирусээр өвчилсөн тохиолдолд хэрхэн эмчилгээнд хамрагдах | Насанд хүрэгчид | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг компанит ажил<br>Зөвлөгөө өгөх<br>Эрт илрүүлэг хийх | Долоодугаар сар |
| 17. | Хүүхдийг хөхөөр хооллолтыг дэмжих | Нярай хүүхдийг 2 нас хүртэл хөхөөр хооллох<br>Бага насны хүүхдийг хэрхэн хооллох, асаргаа, сувилгааны талаар<br>/Албан газруудад хөхөөр хооллох орчин бий болгох/ | Эцэг эхчүүд<br>Жирэмсэн эмэгтэйчүүд<br>Төрийн болон төрийн бус байгууллагууд | ЭМГ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Эхчүүдийн өртөөчилсөн сургалт, хэлэлцүүлэг<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Интернет олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэх | Наймдугаар сар |
| 18. | Өсвөр үе, Оюутан залуучуудын эрүүл мэндийг дэмжих | Өглөөний цайны ач холбогдол<br>НҮЭМ<br>Гэр бүл төлөвлөлт | Өсвөр үе, оюутан залуучууд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг компанит ажил<br>Үе тэнгийн сургалт<br>Өртөөчилсөн сургалт | Есдүгээр сар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгсэл<br>БЗДХалдвар | | ЭМТөв | Зөвлөгөө өгөх<br>Дэвжээ<br>Урьдчилан сэргийлэх үзлэг | |
| 19. | Сэтгэцийн эрүүл мэнд | Стресс бухимдлаа зөв тайлах аргад сургах<br>Бага насны хүүхдийн дэлгэцийн донтолтоос сэргийлье | Эцэг эхчүүд<br>Насанд хүрэгчид | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэргэжилтний зөвлөгөө, хэлэлцүүлэг<br>Сургалт мэдээллийн үйл ажиллагаа<br>Судалгаа дүгнэлт гаргах<br>Зурагт хуудас санамж, зөвлөмж байршуулах | Аравдугаар сар |
| 20. | Ахмад настны эрүүл мэндийг дэмжих | Ахмад настнуудын дунд зонхилон тохиолдох ХБӨ, ХӨ-ний урьдчилан сэргийлье | Ахмад настан | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Ахмад настны дунд зонхилон тохиолдох өвчлөлийн судалгаа, хөдөлмөрийн чадвар алдалт, бие даах чадварыг үнэлэх. Нийгмийн дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлох<br>Сургалт мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулах<br>Гэрийн эргэлт хийх | Аравдугаар сар |
| 21. | Нийтийн бүжгээр хичээллэж эрүүлжье хөдөлгөөн | Албан байгууллага хамт олноороо идэвхтэй хөдөлгөөн нийтийн биеийн тамираар хичээллэх | Насанд хүрэгчид<br>Албан байгууллага хамт олон | ЭМГ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв | Нийтийн бүжгээр хичээллэх сарын аян | Аравдугаар сар |
| 22. | "Зохистой хооллолт-эрүүл байхын үндэс" | Эрүүл хүнс сонгож хэрэглэе<br>Өөх тос, сахар, давсны хэрэглээг багасгах<br>Хүнсний ногоо, жимсний хэрэглээг нэмэгдүүлье | Насанд хүрэгчид | ЭМГ<br>СДЭ<br>Сумын ЭМТөв<br>Өрхийн ЭМТөв | Мэргэжилтний зөвлөгөө, хэлэлцүүлэг<br>Сургалт мэдээллийн үйл ажиллагаа<br>Эрүүл хооллолтын үзэсгэлэн,<br>Судалгаа дүгнэлт гаргах<br>Зурагт хуудас санамж, зөвлөмж байршуулах | Арван нэгдүгээр сар |
| 23. | Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр | Өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж<br>Чихрийн шижин өвчтэй хүний хооллолт, сахарын | Насанд хүрэгчид | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэргэжилтний зөвлөгөө, хэлэлцүүлэг<br>Сургалт мэдээллийн үйл ажиллагаа<br>Судалгаа дүгнэлт гаргах | Арван нэгдүгээр сар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээгээ хэрхэн хянах арга зүйд сургах | | | Зурагт хуудас санамж, зөвлөмж байршуулах<br>Эрт илрүүлэг хийх | |
| 24. | Амьсгалын замын халдварт өвчин болон томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх | -Дулаан хувцаслалт<br>-Дархлаа дэмжсэн эрүүл хоол хүнс хэрэглэх<br>-Гар угаах, өвдсөн тохиолдолд амны хаалт хэрэглэх<br>-Зөв ханиаж найтааж сурах<br>-Дархлаажуулалтад хамрагдах | Сургууль цэцэрлэгийн багш нар<br>Эцэг эхчүүд<br>Сургууль цэцэрлэгийн хүүхдүүд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт | Арван нэгдүгээр сар |
| 25. | Антибиотикийн зохистой хэрэглээ мэдлэг хандлагыг сайжруулах дэлхийн 7 хоног | Антибиотикийн зохистой хэрэглээ<br>Нянгийн тэсвэржилт<br>Эмийн жороор олголт ач холбогдол | Иргэд эмч мэргэжилтнүүд | Бүх шатны ЭМБ, эм хангамжийн байгууллагууд | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, аян зохион байгуулах<br>Гарын авлага тараах материалаар хангах<br>Телевиз, радиогоор зөвлөгөө мэдээлэл хүргэх<br>Эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт | Арван нэгдүгээр сар |
| 26. | ДОХ өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр | БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх<br>Гэр бүл төлөвлөлт<br>Жирэмслэхээс хамгаалах арга хэрэгсэл<br>Бэлгэвчний хэрэглээ | 15-18 насны Өсвөр үеийнхэн<br>25-34 насны залуучууд<br>Өрх толгойлсон эмэгтэйчүүд | ЭМГ<br>БОЭТ<br>СДЭ<br>Сум, Өрхийн ЭМТөв | Мэдээлэл сурталчилгаа өдөрлөг, Үе тэнгийн сургалт<br>Өртөөчилсөн сургалт<br>Зөвлөгөө өгөх<br>Зурагт хуудас, гарын авлага тараах материал тараах | Арван хоёрдугаар сар |

Төлөвлөгөө боловсруулсан: [signature] /Б.Амгалан/ ЭМГ-ын МСС хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 01 сарын 19-ны өдрийн
А/06 тоот тушаалын 2 дугаар хавсралт

# ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ ЖУРАМ

**Нэг. Зорилго:** Хүн амын эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд оршино.

**Хоёр. Тайлагнах журам**

2.1 Эрүүл мэндийн байгууллагууд улирал бүрийн сүүлийн сарын 4 дэх долоо хоногийн лхагва, пүрэв гаригуудад илтгэх хуудас болон мэдээллийн хүснэгтийн дагуу НЭМТөвд тайлагнаж ажиллана. Илтгэх хуудсанд гарсан үр дүн, үйл ажиллагааг товч тодорхой хураангуй бичиж фото зургаар баримтжуулна.

2.2 Илтгэх хуудсыг дараах агуулгын хүрээнд бичнэ.

- Зохион байгуулсан үйл ажиллагааны хэлбэр тоо хэмжээ, хүн амын хамрагдалт, үйл ажиллагаанаас гарсан үр дүн, үр нөлөө зэргийг тусгана

- Төлөвлөгөөнд тусгагдсан ажил хэдэн хувьтай биелэгдсэн.
- Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэхэд гарч байсан бэрхшээл, ололт, бэрхшээлийг
- Төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч тухайн хугацаанд хэчнээн ажил шинээр нэмж хийсэн тухай
- Өнгөрсөн хугацаанд хийсэн ажилд өгөх өөрийн үнэлгээ
- Цаашид анхаарах зүйлсийн талаар тусгаж өгнө.

2.3 Дараах хүснэгтийн дагуу мэдээг бэлтгэж НЭМТөвд ирүүлнэ.

| № | Үнэлгээний чиглэл | I улирал | II улирал | III улирал | IV улирал |
|---|---|---|---|---|---|
| 1. | Шийдвэр гаргагчдын оролцоо | | | | |
| 2. | Хамтарч ажилласан байгууллага аж ахуй нэгж тоо | | | | |
| 3. | Боловсруулсан албан бичиг, тушаал шийдвэрийн тоо | | | | |
| 4. | Хэвлэсэн гарын авлага, тараах материалын төрөл | | | | |
| 5. | Хэвлэсэн гарын авлага, тараах материалын тоо ширхэг | | | | |
| 6. | Олон нийтийн дунд зохион байгуулсан үйл ажиллагааны төрөл | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7. | Аян, Компанит ажил /нийт оролцсон хүн, байгууллага/ | | | | |
| 8. | Өдөрлөг /нийт оролцсон хүн/ | | | | |
| 9. | Сургалт /нийт оролцсон хүн/ | | | | |
| 10. | Бусад /Бичих/ | | | | |
| 11. | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан мэдээллийн төрөл | | | | |
| 12. | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан мэдээллийн тоо | | | | |
| 13. | Олон нийтийн сүлжээнд тавьсан мэдээллийн тоо | | | | |
| 14. | Эрүүл мэндийг дэмжигч өрх | | | | |
| 15. | Эрүүл мэндийг дэмжигч иргэн | | | | |
| 16. | Стандартын бие засах газартай өрхийн тоо | | | | |
| 17. | Бие засах газар, муу усны нүхгүй айл өрхийн тоо | | | | |
| 18. | Тамхинаас гарах оролдлого хийсэн хүний тоо | | | | |
| 19. | Тамхинаас гарсан хүний тоо | | | | |
| 20. | Архинаас гарах оролдлого хийсэн хүний тоо | | | | |
| 21. | Архинаас гарсан хүний тоо | | | | |
| 22. | Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэж буй иргэний тоо | | | | |
| 23. | Нийт зарцуулсан төсөв | | | | |
| 24. | Шинэлэг ажил- Шинэ санаа /нэвтрүүлсэн туршлага, шинэ санаа/ | | | | |
| 25. | Хийсэн судалгаа, шинжилгээний ажлын тоо | | | | |
| | Зорилтод бүлгийн хүн амнаас хамруулсан тоо | | | | |
| 1. | Жирэмсэн эхчүүд | | | | |
| 2. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | | | | |
| 3. | Ахмад настан | | | | |
| 4. | Өсвөр үе | | | | |
| 5. | Жолооч | | | | |
| 6. | Сургууль цэцэрлэгийн эцэг эхчүүд | | | | |
| 7. | Төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид | | | | |

2.3. 2018 оны 12 сарын 5-ны дотор 2018 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангаа дэлгэрэнгүй бичиж ирүүлнэ.

**Гурав. Хүлээгдэж буй үр дүн**

1.1 Тайлан мэдээллийг цаг тухайд нь ирүүлэх нь тухайн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны чадамж, МУ-ын засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүд болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг илэрхийлэх суурь үзүүлэлт болно.

1.2 Эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаагаар чанар, хүртээмжээр нь байр эзэллүүлэх, нийгмийн эрүүл мэндийн шилдэг үйл ажиллагаатай байгууллага, хамт олон шалгаруулахад чухал ач холбогдолтой.

1.3 Нийгмийн эрүүл мэндийн төв дээр улирал бүрийн мэдээлэл, илтгэх хуудсыг авснаар эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэнд, мэдээлэл сургалт сурталчилгааны үйл ажиллагааны статистик мэдээллийн сан үүсгэж ард иргэдэд мэдээлнэ.

1.4 Эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөгөө, зөвлөмжийг НЭМТөвөөс улирал бүр тухай байгууллагат цахимаар болон бичгээр өгөх боломж нөхцөл бүрдэнэ.